



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/234

Бат-Өлзий сум

Г Гэрээ байгуулах тухай Г

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5.2, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Улаан-Ам багийн Хужирт, Төмрөтийн худаг засварын ажлыг иргэн Х.Анхбаяртай шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.

2. Иргэн Х.Анхбаяртай гэрээ байгуулж, ашиглалтын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын бусад хөрөнгө зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



САМГАЛАН